



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022.04.25 № 05/5864
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БОЛОР-ЭРДЭНЭ ТАНАА

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Техник хангамж, сүлжээ хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Батбэхийн Төрбат, Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Шуудан өргөн нэвтрүүлгийн хэлтсийн шуудангийн асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Нямдоржийн Оюун-Эрдэнэ нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3-т “энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх”, 43.6-д “Энэ хуульд заасан журмыг зөрчиж төрийн албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно” гэж заасан байх тул нэр дэвшигчийг Төрийн албаны тухай хууль, бусад салбарын хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхэд хяналт тавьж, Төрийн албаны зөвлөл, салбар зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн тухайн албан тушаалд томилох асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД



142203009020